

А П П А Г Ы Ш



Э А Х У А А А Г Ч

Аллагын захиалагч
Зохиолч: Б.Баярхүү

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Аллагын захиалагч

Сүүлийн дөрвөн сар ямар ч захиалга олддоогүй тул мөнгөний бараа харалгүй 3 сар болсон Нарангэрэл аргаа барж, чаддагаар нь амьдралыг харааж суулаа. Нарангэрэл компьютерийн программ зохиодог мэргэжилтэй. Дунд сургуульд байхын л компьютерт хайр зарлаж өөр юу ч сонирхолгүй явсаар их сургуулийн программ хангамжийн ангийг төгсөөд хүссэнээ эс ч ойр зуурын программ зохиохтойгоо болжээ. Сургууль төгсөөд аль нэг компанид ажилд орё гэж бодсон ч мэргэжлийн дагуу ажиллах боломж олдсонгүй. Монголын компаниуд програм хангамжийг тэр бүр тоодоггүй, хэрэгтэй гэсэн бүхэн нь зах зээл, интернет гээд хаа сайгүй байх тул программистаар ажиллах ямар ч найдлагагүй болжээ. Америк, европ, азийн программистууд хүнд хэрэгтэй бүхнийг хийчихсэн тул Нарангэрэлд нэмж хийх зүйл олохгүй ганц нэг веб сайт хийхээс өөр зүйл сургууль төгсөөд хоёр жил болоход нь олдсонгүй. Монголын мэргэжил нэгт нөхөд нь хэлний толь бичиг, санхүүгийн программ хийхээс өөр ажилгүй тул тэдэнтэй өрсөлдөх боломж ч гарсангүй. Харин аз болж худалдааны нэг компани бараа бүртгэлийн программ захиалж хөлсөнд нь 1000 доллар өгчээ. Тэр мөнгөө хэмнэж, нарийлсаар 4 сарын өмнө дууссан аж. Нарангэрэл одоо 24 настай. Эцэг эх, дүүгийн хамт амьдарна. Өдөржин компьютерийн ард өнжих тул одоо хүртэл охидтой үерхэж дотноссонгүй. Тэгээд ч мөнгөгүй тул хэрхэх билээ. Автобус унаанд дааж, хоолонд оруулан, үзвэр үйлчилгээ үзэхээс эхлээд хайр сэтгэлд мөнгө бүхнээс илүү хэрэгтэй тул зүрхэнд үгүйлэгдэх хүслээ хорьж, эр биеийн хэрэгцээгээ компьютерээр л хангаж амьдрахаас өөр аргагүй.

Нарангэрэл компьютер дээр тоглох зуураа цаашид юу хийж, яаж амьдрах вэ гэж толгойгоо гашилгана. Яах вэ?

Тоглосоор байгаад гарт орсон тоглоомдоо тэр нэг их анхаарахгүй ч дайснаа устган үе бүхнийг төвөггүй давна. Тоглоомынх нь баатар утсаар ирэх захиалга аван, ээлжит хохирогчоо хайн хэнд ч мэдэгдэхгүй устгана. Захиалгаа гүйцэтгэж дуусмагц дансанд нь мөнгө орж ирэн шинэ үе эхлэх аж. Амьдрал энэ тоглоом шиг байсан бол Нарангэрэл төвөггүй мөнгөтэй болохсон. Нэг хүн устгаад л арван мянган доллар. Нарангэрэл тоглоомын баатрыг өөрийгөө хэмээн төсөөлж хожсон мөнгөөрөө юу юу худалдаж авах тухайгаа төсөөлөхөд өөрт нь урамтай байлаа. За энэ нэг захиалга ирлээ. Хээл хахуульд автсан улс төрчийг устгах хэрэгтэй болох нь. Хэрэв алж чадвал арван мянган доллар. Нарангэрэл мэргэн буудагчийн M24 гэдэг буу аван байшин дээр гарч хэвтээд тэрхүү хар нүдний шил, бараан костюмтай, тарган улс төрчийг бааранд орохыг хүлээлээ. Машинаас хоёр бие хамгаалагч нь гарч ирэн эргэн тойрныг няхуур харж байна. Эдэнд харагдаж болохгүй. Тэгвэл улс төрч машинтайгаа зугтан даалгавар амжилтгүй болно. Нарангэрэл товчлууур даран тоглогчоо доош хэвтүүлээ. Ашгүй хамгаалагчид нь харсангүй. Машинаас улс төрч гарч ирлээ. Нарангэрэл хулганаараа бууны байг тохируулаад яг толгой руу нь хараалан хулганы зүүн товчлуурыг дарахад буун дуу тасхийж улс төрчийн толгой зад үсрэн хамгаалагч нар нь сандралдаж эхлэв. Одоо Нарангэрэл хэнд ч мэдэгдэхгүй зугтан гэртээ орох хэрэгтэй. Ингэж чадвал тэр мөнгө хожно. Нарангэрэл компьютерийн гар, хулганы тусламжтай чадварлаг зугтаад гэртээ орж чадахад дансанд нь арван мянган доллар шилжин орж ирлээ. Дараагийн үе, дараагийн захиалга... Гэнэт цахилгаан тасран гэрэл унтарч компьютерийн дэлгэц нь чадхийгээд унтарав. “Дахиад л тог.

Сүүлийн үед энэ цахилгаан ямар их тасарч байнаа. Компьютер нь хүчдэл баригчгүй болохоор дороо шатчихна даа. Сарын өмнө яг ингэж цахилгаан гэнэт тасраад компьютерийнх нь тэжээлийн блок шатан солихоос өөр аргагүй болж билээ”. Нарангэрэл эцэг эхээсээ мөнгө гуйж төвдсөнгүй. Тэд нь мөнгө олох гэж хэрэндээ л зовж явааг тэр ойлгож байгаа болохоор ойр зуурын мөнгө гуйхаасаа ч зовдог байв. Дүү нь энэ жил их сургуулийн гуравдугаар курс тул өөрөөс нь нэг их дээрдэх юмгүй. Тийм болохоор мр3 тоглуулагчаа зарж компьютерээ засуулсан юм. Өөр арга ч байсангүй. Нарангэрэл харанхуйд тэмтэчин ширээн дээрээс цагаа олж харвал 23 цаг өнгөрчээ. Тоглоомдоо анхаараад цаг орой болсоныг ч анзаарсангүй. Тэгээд ч маргааш ажилтай биш, юундаа санаа зовох билээ дээ. Нарангэрэл заримдаа шөнөжин тоглоом тоглоод маргааш нь өдөр хүртэл унтах нь энгийн үзэгдэл болжээ. Өөрийн гэсэн тусдаа өрөөтэй болохоор хэн ч түүнд саад болохгүй, хэнд ч тэр саад болохгүй. Нарангэрэл орондоо орон тоглоомоо сэтгэлдээ үргэлжлүүлэв. Саяны хожсон 10 мянган доллараар юу хийх вэ? Энэ мөнгө жинхэнээсээ өөрт нь байсан бол хамгийн түрүүнд юу авах вэ? Эхлээд ямар ч гэсэн өөрийгөө сайхан хувцаслана даа. Дараа нь... Үеийнх нь залуус ихэнх нь машин унах болсонд Нарангэрэл дотроо их атаархдаг байлаа. Эксел ч хамаагүй машинтай болох юмсан. Хэрэв 10 мянган доллар өөрт нь байсан бол машин л авна даа. Бенз авахад ч арай л хүрэхгүй дээ. Япон тэрэг ч бас муугүй. Дажгүй цэмбэгэр япон машин авчихаад, хөгжмийг нь эцэст нь тултал чангалаад хотоор давхих юмсан. Хажуудаа нэг мисс хүүхэн суулгачихвал бүр янзтай. Дараа нь юу авах вэ? Ингэхэд 10 мянган доллар нь машин аваад л дуусах юм байна. Дахиад мөнгө хэрэгтэй. Дараагийнх нь хохирогч хэн билээ? Хэрэв энэ тоглоом бодитой байсан бол би ийм юм хийж чадах болов уу? гэх бодол Нарангэрэлийн толгойд аажуухан орж ирэв. Хэрэв тоглоом дээр гардаг буу зэвсэг байдаг бол ч ядах юмгүй юм шиг санагдахад мөрөөдөлдөө автан тоглоомыг толгойдоо ургуулан бодлоо. Монголд хохирогч болчихоор хүмүүс хангалттай олон байх шиг санагдана. Зурагт, сонин бүрээр л хэн нэгнийг луйварчин, дээрэмчнээр нь дуудаж булхайг нь дэлгэнэ. Тэгэвч тэднийг барьж хорьж, шийтгэж байгаа юм алгаа. Тэрбум тэрбумаар нь улсаас идэж ууж, хувьдаа завшсан гэгдэх улсууд “нээрээ тийм шүү” гэсэн мэт тарган, цаггалан царайлан зурагтаар их зантайгаар инээд алдан ярилцлага өгнө. Аман дээрээ улс нийгмийнхээ төлөө өдөр шөнөгүй ажилаад байгаа гэх хэр нь ард түмний амьдрал өдөр ирэх бүр доройтсоор. Шүүх, цагдаа нарыг тэд хахуулдчихсан болохоор ингээд л амар амгалан царайлан ард түмнийг бүдүүлэг, соёлгүйгээр нь дуудан доромжлоод явж байна. Тэднийг хэн барж дийлэх билээ. Хэрэв Нарангэрэлд эднийг устга, тэгвэл мөнгө өгье гэвэл лав хийж чадна даа. Тэр тоглоомд хэзээ ч хожигдож байгаагүй юм чинь. Тэгтэл Нарангэрэлийн толгойд нэг санаа гэнэт орж ирэв. Түүнийгээ ургуулан бодож хөгжүүлэхэд болохгүй ч юмгүй шиг санагдахад зүрх нь хүчтэй дэлсэн нойр нь хулжлаа. “Хэрэв үүнийг хийж чадвал тэр дахин мөнгөний гачаал амсахгүй. Харин мөнгө орж ирэх болов уу? За орж ирэхгүй байсан ч яах вэ дээ. Тэртээ тэргүй хийх ажил байхгүй юм чинь оролдоод үзэхэд гарзгүй”. Их мөнгө үнэртэж сэтгэл догдлуулавч хэрэв баригдвал өнгөрнө гэх айдас нэрвэж байв. Тэгсэн ч гэсэн яадаг юм бэ?! Луйварчид бүхнээс илүү баян цаггалан амьдарч байхад эгэл ард, энгийн шударга иргэд өдрийнхөө хоолны мөнгө, ганц бөндгөр талхны төлөө хөлсөө урсгаж явна гэх уур бухимдал айдсыг нь дарж зориг нэмлээ. Баригдахаас айж байгаа бол баригдахгүй байх аргыг олох хэрэгтэй. Программист хүний хамгийн сайн хийж чаддаг зүйл бол байж болох бүр хувилбарыг тооцоолж, хамгийн ашигтайг нь сонгодог арга, ухаан. Нарангэрэл шөнөжин шинэ санаагаа төлөвлөн бодож хэвтээд үүр цайх үед л унтжээ.

12 хүртэл унтаад зөнгөөрөө сэрэн яаран босч нүүр гараа угаахад урьд шөнийн төлөвлөгөө нь

толгойд нь хэв хэвээрээ харин ч тархи нь улам саруулжин шинэ шинэ шийдлүүд ар араасаа урган төрсөөр. Гэрийнхэн нь ажил сургуульдаа явжээ. Нарангэрэл цай, ундаа яаран уугаад компьютерийнхээ ард суулаа.

Нарангэрэл өдөр шөнөгүй суусны хүчинд яг нэг сарын дараа төлөвлөсөн зүйлийнх нь ерөнхий хана босоод ирэв. Энэ хооронд тэр гэрээсээ ч гарсангүй. Эцэг, эх нь “ямар ч хамаагүй ажилд орооч” гэж үглэхэд унтууцан маргалдаад өрөөнөөсөө ч гарахаа байжээ. Эцэг эх нь түүнд үг хэлээд залхсан тул зөнд нь орхиод өрөө рүү нь ч шагайхаа байлаа.

Нарангэрэлийн хийсэн, хийх гэж төлөвлөсөн зүйл нь юу байв гэвэл “ард түмний шүүх” гэсэн нэртэй веб сайт хийж түүндээ ард түмний дургүйцлийг хамгийн их хүргэсэн арван хүнийг ард түмний саналаар шалгаруулах байв. Тэдний хийсэн луйвар, шамшигдуулсан хөрөнгө, хахуульд авсан мөнгө зэргийг баримттайгаар илчилж болох юм. Энэ чинь байдаг л зүйл шүү дээ гэж уншигч та бодож болох юм. Гэвч хамгийн чухал нь, мөнгө олох ганц арга нь туйлын аймшигтай болохыг та мэдэх болно. Нарангэрэл веб сайтаараа санал асуулга явуулж ард түмний хамгийн их үзэн яддаг, үзэн ядахаас өөр зүйл хийж үл чадах нэг луйварчинг тодруулж ард түмний шударга шүүхээр түүнд алах ял төлөвлөх ёстой байв. Энэ санал асуулгад оролцсон хүмүүс дансаар мөнгө хандивлан алуурчинг хөлслөх юм. Алуурчин нь нууц. Луйварчид хэсэг бүлэг шүүгч, эрх мэдэлтэнг худалдан авч болох юм. Харин ард түмнийг бүгдийг нь худал үгээр хуурч, худалдан авч чадахгүй. Шүүх тэдэнд халдаж чаддаггүй юм бол ард түмэн чадна. Ард түмнээс булаасан, тэднээс луйвардсан, тэднээс хулгайлсан төгрөг бүрийнхээ төлөөсийг луйварчид амиараа төлөх ёстой. Нарангэрэл энэ л санааг веб сайтдаа тусгажээ. Гэхдээ тэр хүн алахгүй, алуурчин танил ч байхгүй юм чинь. Ер нь л хүн алах төлөвлөгөө түүнд байсангүй. Зөвхөн хангалттай хэмжээний мөнгө олоод л таг чиг больё гэж тооцоолжээ. Тэгэхийн тулд өөрийгөө маш сайн нууцлах хэрэгтэй. Хэн ч түүнийг мэдэх ёсгүй.

Дахин нэг сар өнгөрсний дараа веб сайт нь бэлэн боллоо. Нууцлал дээр их анхаарсан болохоор ингэж их уджээ. Сайт нь гурван үндсэн хэсэгтэй байлаа. Эхний хэсэгт сайтаар зочлогсод луйварчдыг нэрлэн ард түмний шүүхэд татна. Тэдний булхай луйварыг баримттайгаар илчилсэн байна. Дараагийн шат нь луйварчин гэдэг нь баримтаар нотлогдсон хүмүүсийг ард түмний шүүх алах ял төлөвлөнө. Тэндээс ард түмэнд хамгийн их хохирол учруулсан, улс оронд нөхөж болшгүй гарз учруулсаныг нь ард олны саналаар шалгаруулан сонгож дараагийн шатанд оруулж алах ял заах ёстой байв. Нарангэрэл вэб сайтаа гадаадын нэгэн хост дээр байрлууллаа. Америкийн нэг интернет банкинд хувийн данс нээлгэв. Бэлтгэл ажил үндсэндээ дуусахад монголын хэд хэдэн сайтад халдан рекламаа цацаад вэб сайтаа сурталчиллаа. 14 хоногийн дараа сайтыг нь 2500 орчим хүн үзэж сонирхжээ. Хэд хэдэн авилгач, луйварчин ч сонгогдсон байв. Хагас сар өнгөрсний дараа эхний шатанд хорь гаруй луйварчин бүртгэгдсэн ч хоёр дахь шатанд орсон хүн алга. Мөнгө бол бүр сураг ч үгүйд Нарангэрэлийн урам хугаран энэ санаа нь дэмий зүйл байж дээ хэмээн бодож эхэллээ.

Тэгтэл нэг шар сонин дээр веб сайтынх нь тухай цухасхан мэдээ гарчээ. “Монголд гэмт хэрэг газар авч бүр ил цагаандаа гарчээ. Саяхан нэг веб сайт гэмт хэргийг улаан цайм сурталчилж хүн алах захиалга авах болжээ” хэмээн бичсэн байв. Нарангэрэл энэхүү мэдээг уншаад зүрх нь үхэж харамсч эхэллээ. Анх энэхүү санаагаа хэрэгжүүлэхдээ ийм зүйл гарцаагүй болно гэдгийг сайн мэдэж байсан ч төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн хоёр сар гаруйн хугацаанд

зүрх зориг нь шантарсан байв. Гэтэл шар сонинд мэдээ гарсанаас хойш веб сайтыг нь үзэж сонирхсон хүмүүсийн тоо эрс нэмэгдэж нийгэм тэр аяараа шуугих болов. Мэдээлэл асар хурдацтай, маш ихээр хуримтлагдаж зарим улс төрч, бизнесмэнүүдийн луйврыг тодорхой баримттайгаар ч дэлгэжээ. Вэб сайтыг нь нийт 200 гаруй мянган хүн орж үзжээ. Энэ 200 мянган хүнээс нэг нь л захиалга өгч Нарангэрэлийн дансанд анхны 10 доллар орж ирэв. Нарангэрэл тэрхүү захиалагчийн нэрлэсэн луйварчинг захиалгын буланд тавилаа. Тэр нь улсын төсвөөс 10 тэрбум төгрөг хувьдаа завшсан улс төрч ажээ. Баримт нотолгоо нь ч хангалттай байв. Тэгтэл захиалга далайн түрлэг мэт данс руу нь мөнгө болон цуггаж эхлэв. Одоо Нарангэрэлийн дансанд 4 мянга гаруй доллар цугларлаа. Захиалагчид нь ихэвчлэн 1, 5, 10 доллар шилжүүлсэн байх тул энэ нь бага биш захиалагч байна гэсэн үг. Алах ял төлөвлөгдсөн 20 орчим хүн шалгарлаа. Харин “хэрэгт татагдсан” 45 луйварчин тодрон баримт нотолгоогоо хүлээн жагсана. Цагдаагийнхан энэ хугацаанд зүгээр суусангүй. Вэб сайтыг нь хаалгаж эзнийг нь олохоор ажиллаж эхэлжээ. Гэхдээ энэ тухай Нарангэрэл одоохондоо мэдэхгүй л байв. Дансыг нь одоохондоо хаалгаагүй аж. Данс нээлгэсэн банк нь нэр хүнд, харилцагчийнхаа нууцыг зүгээр нэг хөсөр хаясангүй. Одоо Нарангэрэлийн дансанд 20 орчим мянган доллар цугларсан байлаа. Алах ял төлөвлөгдсөн хүмүүсээс 5 хүн хөдөлшгүй баримт, 98 хувийн саналаар баглагдав. 3 улс төрч, 2 бизнесмэн ч зүгээр суусангүй. Вэб сайтыг нь шүүхэд өгч, амь насаа хамгаалуулна, нэр хүндийг минь гүтгэж гүжирдлээ гэж зурагтаар орилж гарав. Гэвч тэр гээд бариад авах буруутан шүүх, цагдаад олдсонгүй. Нарангэрэл одоо л бүхнийг орхиж тоглоомноос гарах цаг боллоо хэмээн дансан дахь мөнгөө өөр нэг шинээр нээсэн дансанд шилжүүлэв. Ингэсэн нь ч оножээ. Вэб сайтыг нь эрүүгийн цагдаагийнхан хаалгажээ. Бүх зүйл санаснаар нь болсонд Нарангэрэл баярлан хөөрөвч далд айдас үргэлж дагана. 23 мянган доллар нь түүнд 4-5 жил хангалттай хүрнэ. Одоо нам гүмхэн амьдарч энэ бүх дуулиан намдахыг хүлээх л түүнд үлдсэн мэт. Гэтэл түүний вэб сайт нь өөр хост дээр дахин шинээр байршин гарч ирлээ. Нарангэрэл гайхан сайт руу орж үзвэл яг л түүний хийсэн сайт аж. Гэхдээ Нарангэрэл биш өөр хэн нэгэн түүнийг нь ажилуулжээ. Харин аллагын захиалга авах данс нь түүний шинээр нээсэн дансны дугаар байлаа. Нарангэрэл айх, гайхахын туйлд хүрлээ. Хэн сайтынх нь эхийг (source) олж, хэн шинэ дансных нь дугаарыг мэдээ вэ? Уг нь Нарангэрэл бүгдийг маш сайн нууцалсан гэж бодсон юмсан. Вэб сайтын эхийг ч яах вэ хакердаж болно. Харин дансны дугаарыг нь яаж мэдсэн байхав? Нарангэрэл дахин шинэ данс нээлгэн мөнгөө яаран татлаа. Сайт нь шинээр интэрнэтэд байрласан хэдий ч захиалга нэмэгдэж шинэ дансанд нь 5000 доллар шилжин орж амжжээ. Нарангэрэл дансаа хоослон хаасан ч маргааш нь л сайт нь шинэчлэгдэн шинэ дансны дугаар нь илчлэгдсэн байв. Нарангэрэл айж эхлэв. Хэн нэгэн хакер түүнийг салалгүй мөрдөж үйлдэл бүрийг нь мэдээд байх юм. Нарангэрэл уг нь мөнгөтэй л болох гэж энэ бүхнийг эхлүүлсэн ч харин одоо үүнээсээ гарах гэж хичээвч гарт наалдсан бохь адил өөрөөс нь салдаггүй. Тэгтэл түүнийг мөрдөж мөшгөөд байгаа хакераас мэйл хаягаар нь нэгэн захидал ирж улам их айлгав. “Чи нэгэнт тоглоомыг эхлүүлсэн бол дуусгах хэрэгтэй. Зугтах газар чамд үгүй. Хэрэв дахин зугтвал үнэн нүүр царайг чинь нийтэд дэлгэх болно шүү” гэсэн сүрдүүлэг байлаа. Хаяг нь mongoltumen@yahoo.com гэжээ. Нарангэрэл гарах гарцгүй болжээ. Одоо яах вэ? Энэ сүрдүүлэг цагдаа нараас биш нь тодорхой байна. Харин ч тэд түүнийг олсон бол дээр байсан юм. Монгол түмэн гэх энэ хакер түүнийг ажлаа хийхийг тулгаж байна. Тодруулж хэлбэл алах ял заагдсан луйварчдыг ард түмний шүүхийн дагуу алж устгахыг шаардаж байна. Гэтэл Нарангэрэл түүнийг хэрхэн хийх билээ? Эхнээсээ л хүн алах тухай тэр огт төлөвлөөгүй байсан. Гэтэл захиалга нэгэнт өгөгдөж мөнгө төлөгджээ. Нарангэрэл мөнгө хэрхэн олох

билээ гэж санааширч байснаасаа ч илүүгээр шаналж бодолд орлоо. Интэрнетээр алуурчин хайх уу? Тэр алуурчин нь санаан зоргоор юунд олдоо аж даа. Олдлоо ч гэсэн хичнээн төгрөг нэхэх бол? Нарангэрэл бухимдан өрөөн дотуураа холхиж “би юу бодоод байнаа. Алуурчин олох ч гэх шиг. Хүн алах хэрэг үү? Хүн алах захиалга өгөх гэж үү? Хэрэв баригдвал би шууд цаазлуулна ш дээ. Би зөвхөн луйварчдыг үзэн ядах сэтгэлийг ард түмэнд төрүүлж хэдхэн төгрөг олохыг л хүссэн шүү дээ. Хэдэн төгрөг олчихоод л энэ бүхнийг хаяна гэж төлөвлөсөн. Гэтэл одоо алуурчин хайж толгойгоо гашилгаж суух ч гэж дээ. Одоо би юу хийх вэ? Цагдаад үнэнээ хэлэх үү? Тэгвэл ч ял сонсох нь гарцаагүй л дээ. Хэрэв намайг олон түмэн мэдвэл тэд намайг өршөөхгүй. Үеийн үед үзэн ядаж хуруугаараа чичлэх болно. Тэд итгэлээрээ тоглуулсныхаа хариуг надаас хатуугаар авах болно” гэж бухимдаж, нэг үе гуниглаж шаналлаа.

Нарангэрэл интэрнетэд холбогдож сайт руугаа оров. Сүүлийн үед гэрээс гарахаа байсан тул гэртээ интэрнэтийн сүлжээ тавиулан гэрээсээ сайтаа хяндаг болсон аж. Ard-tumnii-shuukh.com сайтад нь яг одоо 7520 хүн холбогдсон байв. Харин нийт зочлогсдын тоо 853620 хүрчээ. Шинэ шинэ мэдээллүүд минут минутаар нэмэгдсээр байв. Урьд нь луйварчдыг л харааж зүхдэг байсан бол харин одоо энэхүү сайтыг зохиосон хүнийг ч харааж загнажээ.

“Ард түмний итгэлээр тоглосон хүн бүхнийг алах хэрэгтэй”, “бидний мөнгийг авсан хүн ажлаа хий. Эс бөгөөс бид чамайг ч гэсэн захиалгад оруулна” гэх мэт аймшигтай захидал иржээ. Нарангэрэл яаж чадахсан билээ. Эхэндээ энэ ердийн л нэг бяцхан луйвар байсан бол харин одоо хүн амины хэрэгтэй холбоотой аймшигтай асуудал болон хувирч Нарангэрэлийн хоолойг дүүжлүүрийн олс адил боож эхэлжээ. Mongoltumen гэх хакераас түүнд захидал ирсэн байхаар нь түүнд нь юу гэж бичсэн байгаа бол хэмээн айж түгшсээр уншив.

“Ард түмэн шударга шүүхийг хүлээсээр удлаа. Тэдний итгэл, найдвар, хүсэл тэмүүлэлийг хэрэв чи хөсөрдүүлбэл ард түмэн чамайг өршөөхгүй шүү. Чамд бодоход 2 хоног болгоход 3 хоногийн хугацаа өглөө. Энэ хугацаанд амласнаа биелүүлж ард түмний шударга шүүхээс гаргасан тогтоолыг гүйцэтгэхгүй бол эргээд ард түмэн чамайг 2 сая хэсэг болтол тасчин хаяна гэж мэдээрэй. Чиний тухай бүх мэдээллийг би мэдэж байгаа. Зугтах гэж оролдох хэрэггүй. цагдаад мэдэгдээд бүр ч дэмий. Бид чамайг хаанаас ч олно. Монгол түмэн” гэсэн байлаа. Нарангэрэл уурласандаа компьютерийнхээ дэлгэцийг алгадаад ухасхийн босч өрөөн дотуураа өлсгөлөн арслан адил нааш цааш холхиж “Новш гэж, ёстой новш юм даа” гэж хараасаар байв. Чухам хэнийг тэгтлээ үзэн ядаж хараасан юм бол? Энэ аймшигтай хэрэгт хутгасан өөрийгөө юу? Эсвэл түүнийг хэлсэн амлалтаа биелүүлэхийг хайр энэрэлгүй шахаж шаардах Монгол түмэн гэгчийг үү? Аль эсвэл энэ бүхний үндэс болсон луйварчдыг юм болов уу? Юутай ч гэсэн Нарангэрэл гарах гарцгүй болжээ. Тэгсэн ч гэсэн тэр хүн алж чадахгүй.

Монгол түмэн гэгчийн түүнд өгсөн тав хоног дуусахад нэг хоног үлдээд байх үед Нарангэрэл шаналсандаа хоол, унднаас гарч амьд сүг аятай болж хувирчээ. Цаг үргэлж өрөөндөө холхин шүдээ тачигнуулавч юу ч хийж чадахгүйдээ бухимдан толгойгоо шааж авна. Эцэг эх нь түүний өрөөнд орж ирэхэд уурлаж орилон хөөж гаргаад хаалгаа дотроос нь түгжижээ. Түүнд зөвхөн яах вэ гэсэн бодол л толгойд нь эргэлдэнэ. Гадаадад дүрвэх үү? Дансан дахь мөнгө нь 30 мянга хэдийнэ хүрсэн болохоор нэг хэсэгтээ л амьдраад байж чадна. Гэтэл гадаад паспорт гаргуулах гэх мэт их ажил нь үлдсэн хэдхэн хоногт яасан ч амжихгүй. Тэгээд ч хэн нэгэн түүнийг гадаа отож хааш нь ч гаргахгүй анаж байгаа биз. Нарангэрэл гэрээс байтугай

өрөөнөөсөө ч толгойгоо цухуйлгахаа байлаа. Монгол түмний түүнд өгсөн тав хоног дуусахад зориг гарган компьютераа асаав. Энэ хугацаанд тэр компьютертээ огт гар хүрээгүй юм. Нарангэрэл интернэтэд холбогдон сайт руугаа ороод юу үзсэн гэж санана. Аллага болжээ. Алах ял заагдсан луйварчин эр алуулсан байв. Хэн нэгэн түүний өмнөөс ялын тогтоолыг гүйцэтгэж энэ хэргийнхээ тухай сайтад нь дэлгэрэнгүй бичсэн байлаа. Нарангэрэл чичирсэн гараар хулганаа барин тэрхүү тэмдэглэлийг уншив.

“Монголын ард түмний хэдэн зуун жил хурааж хуримтлуулан, өдийг хүртэл хадгалж, хамгаалж ирсэн газрын баялагийг харийнханд худалдсан луйварчин, улсын их хурлын гишүүн Батгэрэлийг ард түмний шударга шүүхээр буруутай хэмээн тогтоож хахуульд авсан арван сая долларынх нь хариуд алах ял заасныг ёсоор болгов. Энэхүү хэргийг нийт монголын ард түмний саналаар гүйцэтгэсэндээ би туйлын сэтгэл хангалуун байна. Надад хүн алсан гэх гэмшил огт төрөөгүйгээр үл барам монголчуудынхаа өмнө хийсэн баатарлаг үйл гэж бодном. Эх орныхоо сөөм газрыг ч бусдад алдахгүй хэмээн цусаа урсган байлдаж явсан цэрэг эрс шагнал хүртдэгийн адилаар миний бие тийм шагнал, урмыг та бүхнээсээ хүснэм. Та бүхний сэтгэл оюуныг бага ч болов амраасандаа би баяртай байгаагийн хамт хэрхэн энэхүү ялын тогтоолыг гүйцэтгэснээ та бүхэндээ дэлгэрэнгүй өгүүлье.

Би алах ял заагдсан их хурлын гишүүн Батгэрэлийг хоёр өдөр дагаж мөрдсөн билээ. Тэрээр эхний өдөр өглөө гэрээсээ гарч засгийн газрын ордонд ирээд оройн есөн цаг хүртэл тэндээсээ гаралгүй байсаар нэг өдөр өнгөрөв. Дараах өдөр мөн адил гэрээсээ гарч засгийн газрын ордон дахь ажилдаа ирээд өдрийн 12 цагийн үед гадагшаа гарав. Тэрээр хоёр хамгаалагчтайгаа тусгай хамгаалалтын хар өнгийн жипээр явсаар их тэнгэрийн ам руу явсан. Тэнд би түүнийг гарч ирэхийг 3 цаг орчим хүлээлээ. 15 цагт тэрээр их тэнгэрийн амнаас хөдөлж Чингис зочид буудал руу явлаа. Би түүнийг дагасаар Mr.Wang ресторанд ороход нь гадаа нь хүлээв. Тэрээр хамгаалагч нараа гадаа үүдэнд хүлээлгэн ганцаараа солонгос бололтой 3 хүнтэй удтал ярилцаж хоол идээд гэрийн зүг явсан. Гурав дахь өдөр нь би түүнийг мөн л гэрийнх нь гаднаас ажил хүртэл нь дагасан юм. Би хэдийгээр маш их өлсөж, ядарч байсан ч монгол түмнийхээ даалгавраар энэ бүхнийг хийж байсан тул сэтгэлээ барьж биеэ хүчлэн хүлээсээр байлаа. Тэрээр гарч ирэхгүй удтал тэндээ бүгээд орой 19 цагийн үед гарч хувийнхаа хамгаалагч, жолоочийн хамт “Цэцэг” зочид буудал руу явав. Би тэр буудал руу нь ороход тэрээр ресторанд нь байхгүй байлаа. Харин хувийн бие хамгаалагч нь үүдний танхимд ганцаар сууж байв. Тэрээр над руу маш сэжигтэй харсаар байх тул би аргагүй тэндээс гарч ойролцоохон нь нуугдан хүлээлээ. Орой 21 цагийн үед Батгэрэл нэг хятад хүнтэй гарч ирээд “Тан луу” хэмээх хятад хоолны ресторанд орцгоолоо. Би энэ л өдөр бүх ажлыг амжуулах гэж төлөвлөсөн болохоор тэднийг даган орж булангийн ширээнд суугаад тэднийг ажиглаж суулаа. Батгэрэл хамт ирсэн хятад эртэй орчуулагч хүүхнээр дамжуулан ярилцаж инээд алдан сууна. Орчуулагч хүүхэн нь хэзээ энд ирсэнийг мэдэхгүй. Бодвол энд тэднийгээ хүлээж байсан биз. Батгэрэл их л сэтгэл хангалуун инээд алдаж суух нь монголын газар шорооноос энэ харийн эрд худалдаад түүндээ баясаж суугаа биз гэж би бодон уур минь хүрч байлаа. Монгол хүн өөрсдийн газар дээр газар ухаж болохгүй хөөгдөж туугдан нинжа хэмээн адлагдаж байхад хэн нэгэн мөнгөтэй харийн хүн миний монголын газар шорооноос хэдэн арван га талбайг 15-60 жилээр эзэмшин хамаг баялагийг нь цөлмөж суухыг би хараад тэсч сууж чадаагүй билээ. Тиймээс ч энэхүү наймааг эрхэлж хээл хахуулиар бүхнийг худалдан авч, монгол улсын хуулийг гууль болгосон Батгэрэлийг алахаар сэтгэл шулуудсан

билээ. Манай сайтад хандсан 600 мянган шударга иргэн ч минийхтэй адил бодолтой байсан юм. Тэд архи ууж, хятад хоол идэн ихэд тухалжээ. Харин тэгтэл би, жирийн нэг монгол иргэн тэр үнэтэй гуанзанд хамгийн хямдхан хоолыг ч авч дийлэхгүй шахам сууж байгаадаа уур минь хүрч байв. Батгэрэл бие засахаар нойл руу явах үед би одоо л амжуулахгүй бол болохгүй гэж өөртөө шивнэв. Азаар хамгаалагч нь гадаа байсан юм. Би түүний араас нойлын өрөө рүү ороход тэрээр бие засаж дуусаад гараа угааж байлаа. Над руу гудамжны тэнэмэл харсан аятай зэвүүрхэн харахыг би анзаараад сэтгэл минь шулуудан хармаанаасаа хутгаа гарган нуруу руу нь дүрлээ. Хамаг хүчээрээ дүрсэн хэдий ч нурууных нь яс нь хутганд таарч олигтой сайн орсонгүй. Батгэрэл аймшиг дүүрэн нүдээр над руу харж хашгирах гэхэд нь хоолойд нь хутга зоолоо. “Монголын газар шорооноос гударсан хохь чинь гэж би дотроо бодож байв”. Дараа нь цээж рүү нь дүрлээ. Монголын ард түмнээс луйвардан завшсан төгрөг бүрийнх нь тоогоор түүнийг дүрье гэж бодсон боловч тэр хэдийнээ үхжээ. Би хутгаа өвөртлөөд тэндээс яаран гарсан юм.

Би ингэж та бүхний шүүхийн тогтоолыг гүйцэтгэлээ. Монголын ард түмэн нэг луйварчнаар хорогдлоо. Одоо дараагийн алуулах ялтны ээлж. Та бүхэн саналаа ирүүлнэ үү. Захиалга гүйцэтгэгч” гэж бичжээ. Нарангэрэл тэрхүү дэлгэрэнгүй бичсэн аллагын тухай дахин дахин уншаад энэ бүхэн үнэн бодит зүйл гэдэгт итгэлээ. Алуурчин олджээ. Харин тэр хэн бол? Хэн Нарангэрэлд туслаж өмнөөс нь ажлыг нь гүйцэтгэсэн юм бол? Нарангэрэл сайтад зочлогсдын сэтгэгдлийг яаран уншив. Бүгд алуурчинг магтаж “ард түмний хүү” гэж нэрлэсэн байв. Нарангэрэл яахаа мэдэхээ байчихлаа. Ямар ч гэсэн тогтоол гүйцэтгэгдэж. Гэхдээ монголчууд өөрийг нь тогтоол гүйцэтгэгч алуурчин гэж бодож байгаа шүү дээ. Хэрэв энэ сайтыг Нарангэрэл хийсэн, энэ бүхэн түүний санаа гэдгийг хэн нэгэн олж мэдвэл өөрийгөө хүн алсан ялаас мултлах арга түүнд олдохгүй. Тэр хэрэг хийгээгүй мөртлөө алуурчин боллоо. Одоо л зугтах хэрэгтэй. Тэр хэлсэн амандаа хүрсэн. Хэдий өөрөө хийгээгүй ч амласандаа хүрч ялын тогтоолыг гүйцэтгэсэн. Одоо түүнийг гадаадад гараад явчихад монголчууд түүнийг буруутгахгүй. Нарангэрэл гэрээс гарч гадаад паспортоо хөөцөлдөхөөр гадуур хувцасаа хайн шүүгээгээ онгойлгох үед хаалгыг нь хэн нэгэн тогшлоо. Энэ үед 13 цаг болж байсан тул цайныхаа цагаар ирсэн ээж нь хаалга онгойлгож өгөв. Үүдэнд хэдэн хүмүүс ярилцахыг Нарангэрэл сонсон “хэн юм бол?” гэж сэрдэн бодоод хөшөө адил зогсож чимээ анирдан чагнав. Гэтэл өрөөнийх нь хаалгыг нээн цагдаа хувцастай гурван хүн өрөөнд нь орж ирэхэд Нарангэрэл цагдаа хараад айж балмагдсандаа хөдөлж үл чадан дэмий л амаа ангайлган зогсоход хоёр цагдаа түүн рүү хурдан дөхөн ирж

-Иргэн Нарангэрэл таныг хүн амины хэрэгт сэжиглэн баривчилж байна гэж хэлээд гарыг нь ард нь аван гав зүүлгэхэд л Нарангэрэл сэхээ орон

-Та нар юун хүмүүс вэ? Би гэмгүй хүн гэж хашгиран тэднийг мөрөөрөө түлхэн хаалга руу зүтгэхэд нэг цагдаа араас нь зууран дэгээдэн унагаад гарыг нь дээш өргөлөө. Гар нь тэсэхийн аргагүй өвдөхөд Нарангэрэл ёолон орилов. Ээж нь хүү рүүгээ тэмүүлэхэд өөр нэг цагдаа хорин зогсоов. Нэг цагдаа өрөөг нь битүүмжилэхээр үлдэж хоёр нь Нарангэрэлийг цагдаагийн машинд суулган авч одлоо.

...Нарангэрэлийг цагдаагийн газрын урьдчилан хорих өрөөнд ганцааранг нь тусгаарлан хорьжээ. Гэнэгүй байж байгаад гэнэт баригдсандаа Нарангэрэл эхэндээ цочирдон ноомой

байдалтайгаар явж энд ирэн төмөр хаалганы цаана хоригдсон хойноо л сэхээ орон зүрх нь үхэж дотор нь бачуурлаа.

“Цагдаа нар яаж намайг олов оо? Ямар ч сэжиг ажиг авалгүй байж байгаад ёстой нэг чадууллаа даа. Одоо яах вэ? Хамаг үнэнээ хүлээгээд ялаа багасгахаа л бодохгүй бол болохгүй. Аягүй бол хүн алсан хэрэг над дээр тохогдоно. Сүүлийн тав хоног намайг гэрээсээ гараагүй гэдгийг бүгд мэдэж байгаа. Эцэг, эх, дүү нар ч нотлоно. Хэрэгтэй бол байрныхан маань ч гэрчлэх биз. Би тэр “Тан луу”-д нь очоо ч үгүй. Намайг тэнд очоогүй гэдгийг зөөгч нар нь ч нотлох биз. Миний хийсэн хэрэг бол луйвар хийх зориулалттайгаар вэб сайт хийсэн. Өөр зүйл үгүй. Бусдаас авсан мөнгө нь ч хэвээрээ байж л байгаа” гэж бодон бага ч болов тайвшраад үнэнээ л хэлэх, гэхдээ өөрт гэм хал багатайхан шиг юу гэж хэлэхээ бодон сууж байтал байцаалтанд дуудлаа. Хүйтэн хонгилоор хуягт туугдан явсаар байцаагчийн өрөөнд ороход буурал орсон үсээ арагшаа самнасан 40 гаруй насны нүдэнд дулаахан байрын байцаагч том модон ширээний ард бичгийн машинаар юм бичин сууж байв. Нарангэрэлийг дагуулж ирсэн цагдаа түүнийг модон сандал дээр суулгахад байцаагч түүн рүү харснаа

-За эхнээс нь бүгдийг яриад байгаарай гэв. Нарангэрэл дөлгөөн ааштай байцаагч таарсанд баярлан

-Би бүх үнэнээ хүлээе. Бүх хэрэг вэб сайтаас болсон юм гэхэд байцаагч түүн рүү хөмсөг зангидан хараад

-Хүлээж бай. Эхлээд миний асуултанд хариулаадах гээд овог, нэр, гэрийн хаягийг нь бичиж авав. Ерөнхий асуултаа дууссаны дараа

-За одоо бүгдийг эхнээс нь ярь даа гэлээ.

-Би 3 сарын өмнө нэг вэб сайт хийсэн юмаа. Ард түмний шүүх цэг ком гэсэн хаягтай. Би хүн алах зорилгоор энэ бүхнийг хийгээгүй. Зүгээр л сонин дээр гарсан хээл хахууль, луйвар булхайд автсан хүмүүсийг тодруулах зорилгоор хийсэн юм. Гэтэл миний сайтыг хэн нэгэн ашиглаж агуулга, хэлбэрийг нь өөрчилчихсөн байсан гэхэд байцаагч түүн рүү хялайн харж

-Юун вэб мэб вэ? Их хурлын гишүүн Батгэрэлийг ямар зорилгоор, яах гэж алсанаа л яриадах гэхэд Нарангэрэл бачимдан

-Би ямар ч хүн алаагүй. Би таньд хэлж байна шүү дээ. Тэр вэб сайтыг ашиглаж хэн нэгэн миний өмнөөс энэ бүхнийг хийсэн байна лээ. Тэрнээс биш би хэнийг ч алаагүй гэхэд байцаагч хэлсэн бүхнийг нь бичиж аваад бугуйн цаг руугаа харан

-Байцаалт өнөөдөртөө ингээд дууслаа. Хэрэв хэргээ хүлээхгүй гүрийгээд байвал өөрт чинь л муу даа гээд Нарангэрэлийн ард зогсож байсан цагдаад толгой дохиод цаадах нь

-Бос гэж зандараад Нарангэрэлийг аваад гарлаа. Байцаагчийн өрөөнөөс гараад түрүүний хорьж байсан өрөө рүү биш шал эсрэг зүг түүнийг дагуулан явж нэг хаалгаар гадагшаа гарахад тэнд нь хөх өнгөн дээр цагаан судалтай битүү машин зогсож байв. Нарангэрэлийг тэр машин руу чихэхэд Нарангэрэл сандран

-Намайг хааш нь аваачих гэж байгаа юм бэ гэж орилоход цагдаа түүний нуруу руу бороохойгоор цохин

-Дуугүй машинд суу, байх ёстой газарт чинь л хүргэх гэж байна гэж зандарлаа.

Түүнийг “Ганц худаг” хэмээх урьдчилан хорих газрын камерт хорив. Хааш хаашаагаа дөрвөн алхам бүрсгэр саарал өнгөтэй шоронгийн нэг өрөөнд хоригдсон тэрээр байж ядан гашуудаж толгойгоо барин хөдлөхгүй хэвтсээр. Ор болгосон модон наарнаас шоронгийн эхүүн муухай үнэр үнэртэнэ. Түүнийг хоёр өдөр огт байцаасангүй. Нэг удаа л хуяг орж ирэн хэдэн хуудас цаас, нэг бал өгч “хийсэн бүх хэргээ нэгд нэгэнгүй бич” гэжээ. Нарангэрэл түүнд нь бүх явдлаа бичиж эцэст нь өөрийгөө буруугүй гэдгээ амь насаараа тангаргалав. Тэр бүх хэргээ үнэнээр нь бичсэн. Хийсэн хэрэгтээ таарсан шийтгэлийг ч хүлээхэд бэлэн, харин хүн алсан хэргийг бол яасан ч хүлээхгүй. Тэр үнэхээр хүн алаагүй юм чинь. Шоронгийн угаадас шиг хоолыг тэр идсэн ч үгүй. Хоолойгоо норгох гэж л хүйтэн хар цай ууж байлаа. Оройн хоолны үеэр хуяг тавагтай хоолыг түүнд өгөн

-Үүнийг сайн гудар гэж нэг л сонин аясаар хэлснээ нүд ирмэх шиг болжээ. Нарангэрэл сэртэсхийн түүн рүү харсан боловч төмөр хаалга аль хэдийн хаагдаж нөгөө хуяг алга болсон байв. Нарангэрэл шалан дээр тавьсан хоол руу сэжиглэсэн байртай харлаа. “Энэ хоолонд арай хор хийсэн юм биш биз. Монгол түмэн гэх хакер түүнээс салахгүй дагаж энд хүртэл түүний гар хүрсэн юм биш байгаа? Эсвэл?...” Хоригдлуудад хоолонд нь төмрийн хөрөө, хуурай зэрэг зүйл хийж өгөн шоронгоос оргоход нь тусалдаг тухай адал явдалт номноос уншиж байсан нь гэнэт санагдан төмөр тавагтай хоолыг аван тэртэй тэргүй өөрөөс нь өөр хэн ч үгүй битүү саванд байгаа хэрнээ сэрэмжлэн ийш тийш хараад ганц нэг мах, зузаан хэрчсэн гурил хөвсөн шөлийг хуруугаараа хутгахад тэнд нь үнэхээр нэг юм байна. Гадуураа гялгар уутаар сайтар боосон хуруун чинээ зүйл. Нарангэрэлийн амьсгал дээрдэн түүнийг яаран аваад өрөөний булан руу ухасхийн хүрч суугаад дахиад л эргэн тойрныг нягтлан харлаа. Шоронд нам гүм. Нарангэрэл тэрхүү гялгар уутаар боосон зүйлийг задалбал хуйлсан бичиг байв. Хөх өнгийн балаар татлан бичсэн тэрхүү захидалд ингэж бичжээ.

“Чи хэдийгээр баригдсан ч монгол түмэн чамайг нүд салгахгүй харж байгаа. Цаг нь болоход монголын ард түмэн чамайг суллах болно. Учир нь чи бол ард түмний хүү шүү дээ. Тэсвэртэй байж суллагдах цагийг хүлээ. Монгол түмэн” гэж бичжээ. Нарангэрэлийн зүрх хүчтэй дэлсэн итгэл найдвар төрж, амьд авах их хүсэл оргилж эхэллээ. Монголын ард түмэн түүнийг мартаагүй юм байна. Шаардлагатай үед хөсөр хаяхгүй юм байна. Хэрэгтэй үед ард түмэн бослого гаргаад ч хамаагүй түүнийг суллахад бэлэн юм байна гэдгийг Нарангэрэл ухааран ард түмнээрээ бахархаж өөрийнхөө хийсэн хэргийг зүгээр нэг булхай луйвар төдий юм биш байсаныг ойлголоо. Хэдийгээр тэрээр энэ хэргийг луйварын зорилгоор эхэлсэн ч түүний хийсэн бүхэн ард түмэнд таалагдаж түүнийг ард түмэн баатраа болгожээ. Ард түмэнтэйгээ байсан цагт тэр ганцаардахгүй юм байна. Нарангэрэл тэрхүү итгэл найдварын оч болсон эвхмэл бичгийг энгэрийнхээ халаасанд хийж жаргалтайгаар инээмсэглэн нүдээ аньж шоронгийн хүйтэн хана налав.

Маргааш нь Нарангэрэлийг байцаалтанд дуудлаа. Ганц худгийн нэг давхарт түүнийг байцаалтын өрөөнд оруулж ирэхэд урьдны танил настай байцаагчаас гадна нас залуу өөр нэг мөрдөн байцаагч цуг байлцав. Нарангэрэл энгэрийнхээ халаасыг дарахад тэнд нь өчигдөрийн

захидал тэмтрэгдэн зориг нэмнэ. Одоо бол бүхнийг үгүйсгэх биш харин ч илүү ухаалаг байж ард түмэнд таалагдах зүйлийг л хэлэх хэрэгтэй. Нарангэрэл заасан сандал дээр нь сууж тэднийг бардмаар харж байв. Залуу мөрдөгч түүн рүү хялайн харж, настай байцаагч бичгийн машин өмнөө тавин цэвэр цаас, хорын хар цаастай хамт голд нь хийх зуураа

-За хийсэн хэргээ үнэнээр нь өчөөд байгаарай гэж тушаахад Нарангэрэл хоолойгоо засан

-Би урьд нь хэлсэн шүү дээ. Бүх хэрэг миний вэб сайтаас үүдэлтэй гэж. Тэрхүү вэб сайтаараа би ард түмнээс санал асуулга явуулж монголын ард түмэнд хохирол учруулж, тэдний татварын мөнгийг хувьдаа завшсан луйварчдыг илчилэхийг хүссэн юм гэхэд настай байцаагч бичгийн машинаараа бичихээ больж

-Чи гол юмаа ярь. Хүн алсан хэргийнхээ тухай л ярь гэж байна шүү. Юун вэб сайт энэ тэр вэ? Битгий булзааруулаад бай. Бүх нотлох баримт бүрдсэн. Чи ингэж жүжиглэснээрээ өөртөө л ял нэмүүлэх болно шүү гэж ширүүхэн хэлэв. Нарангэрэлийн өөртөө итгэлтэй байдал замхран зүрх үхэн

-Ямар нотлох баримт? Би хүн алаагүй гэж бувтнахад настай байцаагч бухимдан ширээнийхээ нүдийг онгойлгоод хэдэн фото зураг гарган

-Чи мэдэн будилсаар байна уу? Май энийгээ үз. Чиний хувцасны шүүгээнээс олсон хохирогчийн цустай чиний хувцас гээд нэг зураг түүн рүү шидээд

-Май, энэ чиний гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн хутга гээд дахиад нэг зураг өөр рүү нь шидэн өгөв. Бас хэдэн хуудас цаас ширээн дээрээ тавьж

-Энэ бол хэрэг гарсан “Тан луу” рестораны зөөгч, үйлчлэгч нарын өгсөн мэдүүлэг, чамайг мөн гэсэн нотлох баримт гээд дахин нэг цаас гарган

-Энэ чамайг “Тан луу”-гаас гэр рүү чинь хүргэж өгсөн таксиний жолоочийн мэдүүлэг гэж хэлэхэд энэ бүхэнд балмагдсан Нарангэрэлийн толгой манаран өрөөн доторх зүйлс эргэлдэх шиг боллоо. Ширээн дээр түүний өмсөх дуртай бэлтгэлийн цэнхэр цамц нь цусанд хутгалдсан байдалтай зураг байна. Өөр нэг зураг дээр тэдний махны хутганы зураг байна. Ишийг нь хар өнгийн цахилгааны лентээр битүү боосон тэр хутгаа Нарангэрэл танив. Хутганы ирэн дээр цус наалджээ. Нарангэрэл үг хэлэх ч чадалгүй болон амаа ангайлган хөшиг. Залуу мөрдөн байцаагч түүн рүү хайхрамжгүй харан

-Таны бичгээр өгсөн мэдүүлгийн дагуу танай гэрийн компьютерийг бид шалгасан. Тэнд таны яриад байгаа вэб сайт чинь үнэхээр байсан гэхэд Нарангэрэл сая л нэг амьсгал авахтай болж түүн рүү царайчлан харвал мөрдөн байцаагч

-Гэхдээ тэр вэб сайт чинь интернэтэд тавигдаагүй байсан. Бид интернэтээс ямар ч тийм нэртэй сайт олоогүй гэхэд Нарангэрэлийн амьсгал давхцан зүрх нь зогсчих шиг болов.

-Гэ...гэхдээ... тэнд ... хүмүүс ... сэтгэгдэл гэж арай чамай шивнэхэд залуу мөрдөгч ширээн дээр баахан сонины хайчилбар гаргаж ирэн

-Та энийг яриад байна уу? Энэ бүхэн таны хийсэн сонины хайчилбар, цуглуулга. Таны вэб сайт дээр бичсэн бүхэн энэ сониноос хуулбарласан зүйлс гэдгийг бид тогтоосон. Та л энэ бүхнийг өөрөө шивсэн гэдгийг ч бид олж мэдсэн. Тэгээд ч танай компьютер интернэтэд холбогдоогүй байна билээ гэхэд Нарангэрэлийн хоолой зангиран нүдийг нь нулимс бүрхлээ. Арай ч дээ? Юу болж байнаа? Энэ бүхэн солиорол байсан гэж үү? Вэб сайт, дансан дахь мөнгө, хакераас түүнд ирүүлсэн захидалууд. Энэ бүхэн юу байсан хэрэг вэ? Гэнэт Нарангэрэлд халаасан дахь захидал нь санаанд оров. Тэрээр яаран энгэрийн халаасаа ухвал тэнд нь бөөрөнхийлж базсан шоронгийн өглөөний цайнд өгдөг талхны түүхий гурил байсанд түүн рүү гайхан харлаа. Энэ бичгийг тэр өчигдөрхөн авсан шүү дээ. Өнөө өглөө ч гэсэн уншиж байсан. Байцаалтанд орохын өмнө хүртэл энэ бичиг халаасанд нь байсан. Хэн ч түүнд хүрээгүй. Гэтэл одоо гурил болчихсон байдаг?! Настай байцаагч Нарангэрэлийн бичгээр өгсөн мэдүүлгийг түүн рүү сарвайн

-Та энэ цаасны буланд бичсэн зүйлээ тайлбарлаж өгнө үү гэж хэлэхэд түүн рүү нь онож ядан харахад өчигдөр Монгол түмнээс авсан захидал нь байлаа. "...Учир нь чи бол монголын ард түмний хүү шүү дээ. Тэсвэртэй байж суллагдах цагийг хүлээ. Монгол түмэн" гэх бичгийг арай ядан уншиж амжив. Нарангэрэл бүхнийг ухаарлаа. Ямар ч Монгол түмэн гэж байхгүй. Ямар ч вэб сайт, захиалга, алуурчин байгаагүй юм байна. Энэ бүхэн түүний төсөөлөл байжээ. Бодитой юм гэвэл цусанд будагдсан хувцас, ирэнд нь цус тогтсон хутга л байна.

Улсын их хурлын гишүүн Батгэрэлийг алсан гэдэг нь 100 хувь тогтоогдсон Нарангэрэлийг шоронгийн тусгаарлан хорих өрөөнд түгжлээ. Эмч нар түүний сэтгэцийг шинжлэн үзээд "ухаан санаа нь самуурч сэтгэцийн сааталд орсон" гэж нэгэн дуугаар тогтоожээ. Түүнийг хэрхэн шийтгэхийг шүүгч нар шийднэ.

Нарангэрэлийн гарыг ард нь хүлсэн байлаа. Тэрээр хэд хоног ухаан мэдрэлгүй шахам байж байгаад дөнгөж сая л ухаан оров. "Би галзуурсан юм гэж үү? Энэ бүхэн, гурван сарын хугацаанд хийсэн бүхэн минь солиорол байсан гэж үү" хэмээн бодоход түүний дотор бачууран гол нь харлана. Түүний толгой дүйрч, амьд явах ямар ч сонирхолгүй болжээ. Гэнэт хажуу өрөөнөөс нь хана тогших чимээ гарахуйд Нарангэрэл хана руу айсан нүдээр ширтлээ. Түүний нүд галзуу хүнийх шиг ийш тийш тэнүүчлэн бүлтэгнэнэ. Хананы цаанаас хэн нэгний бүгт дуу гарч

-Хөөе ард түмний хүү байна уу? гэж дуудах сонсогдлоо. Нарангэрэл самуурсан ухаанаа арай гэж хүчлэн чимээ чагнавал нөгөө сөөнгө дуу дахин сонсогдож

-Бид чамайг мартаагүй шүү. Монголын төлөө хийсэн бүхнийг чинь бид мартаагүй. Тийм болохоор бид энэ бүхнийг зохиосон юм. Одоо чамайг сэтгэцийн өвчтэй гэж дүгнэсэн болохоор ял шийтгэл өгөхгүй. Сэтгэцийн эмнэлэгт хэвгүүлнэ. Тэр үед монголын ард түмэн чамайг суллах болно. Тэсвэртэй байгаарай гэж хэллээ.

2009 он

*Уншигч таны магтаалд урамшиж, шүүмжлэлд баярлан илүү сайныг бүтээх хүсэл,
мөрөөдлөөр жигүүрлэгдэх тул*

bayar_kh@yahoo.com хаягаар саналаа илгээнэ үү.

Table of Contents

[Аллагын захиалагч](#)